



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Барилга байгууламж балансаас баланст  
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн “Нийтлэг үйлчилгээний алба” ОНӨААТҮГ-ын баланст бүртгэлтэй, нийт 517,782,829.35 (таван зуун арван долоон сая долоон зуун наян хоёр мянга найман зуун хорин есөн төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий нийтийн ахуйн үйлчилгээ, халуун усны барилга байгууламжийг тус дүүргийн “Усан спорт сургалтын төв” ОНӨУТҮГ-ын баланст шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116100306